



# НИЙТИЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ

## Нийтийн тээврийн бодлогын газар

Нийслэлийн тээврийн салбарын албан хаагч, ажилтан, их дээд сургуулийн багш, судлаач, иргэдийн хэрэгцээнд зориулж хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг эмхэтгэн гаргаж байна.

Хянасан: НТБГ-ын дарга Д.Отгонжаргал

Эмхэтгэсэн: Б.Эрдэнэбилэг

Б.Болорцэцэг

Э.Минжинсор

Б.Энхзул

**ӨМНӨХ ҮГ**

Нийслэл Улаанбаатар хотын хүн амын өсөлт болон хотжилт эрчимтэй явагдаж байгаатай холбогдуулан нийтийн тээврийн олон төрөлт үйлчилгээг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхдээ шинжлэх ухаан технологийн шийдэлд суурилсан, Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөх, олон улсын гэрээ, захиргааны хэм хэмжээний актыг боловсронгуй болгох, тэдгээрийг чанд мөрдөж ажиллах нь нэн чухал юм. Монгол Улсын Засгийн газар, нийслэлийн удирдлагаас 2021-2024 онд нийтийн тээврийн том, дунд, угсраа, давхар, цахилгаан болон дизель хөдөлгүүртэй 1020 автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэлтийг эрчимжүүлэн, нийтийн тээврийн салбарт ажиллагсдын хүний нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зарим мэргэжилтний цалин хөлсийг хоёр дахин нэмэгдүүлж, иргэдэд соёлтой үйлчлэх хандлагын өөрчлөлтийн талаар олон талт ажлуудыг өрнүүлээд байна.



Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12-р сарын 7-ны өдрийн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуульд зааснаар нийтийн тээврийн төрөл, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийтийн тээврийг хөгжүүлэх санд 2024 онд төвлөрсөн хөрөнгөнөөс нийтийн тээврийн парк шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нөхцөл бүрдээд байна.

Засгийн газрын 2024 оны 2-дугаар сарын 28-ны өдрийн 81 дугаартай тогтоолоор оноосон нэрийг “Нийтийн тээврийн бодлогын газар” болгон өөрчилж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/443 дугаартай захирамжаар тус газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан.

Монгол Улсад тэртээх 1925 онд байгуулагдсан “Тээх нэвтрүүлэх газар”, “Монгол транс нийгэмлэг”-ээс улбаатай Нийтийн тээврийн бодлогын газар үүсэж хөгжсөний 55 жилийн ойг тохиолдуулан салбарын үе үеийн удирдлагууд, ахмад ажилтнууд, тэдний залгамж халаа болсон алба хаагчид, хамтран ажилладаг аж ахуй нэгж, байгууллагууд болон гэр бүлийнхэнд тань ажлын амжилт эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Та бүхний “Алтан шар зам өлзийтэй байх болтугай”

НИЙТИЙН ТЭЭВРИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

**ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ****Гарчиг****Өмнөх үг****Нэг. Монгол Улсын Үндсэн хууль /хэсэгчилэн тусгав/.....8****Хоёр. Монгол Улсын хуулиуд**

2.1. Автотээврийн тухай хууль .....	12
2.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль .....	24
2.3.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль .....	39
2.4.Монгол Улсын автотээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль.....	47
2.5.Иргэний хууль /холбогдох хэсэг/.....	52
2.6.Төрийн хяналт шалгалтын тухай хууль /холбогдох хэсэг/ .....	59
2.7.Зөрчлийн тухай хууль /холбогдох хэсэг/ .....	66
2.8.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /холбогдох хэсэг/ .....	71
2.9.Ахмад настны тухай хууль /холбогдох хэсэг .....	75
2.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /холбогдох хэсэг.....	76
2.11.Цагдаагийн албаны тухай хууль /холбогдох хэсэг/ .....	78
2.12.Дотоодын цэргийн тухай хууль /холбогдох хэсэг/ .....	79
2.13.Гамшгаас хамгаалах тухай хууль /холбогдох хэсэг/ .....	80
2.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /холбогдох хэсэг/.....	81
2.15.Зөвшөөрлийн тухай хууль /холбогдох хэсэг/ .....	87
2.16.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /холбогдох хэсэг/ .....	88
2.17.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль /холбогдох хэсэг/.....	90
2.18.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /холбогдох хэсэг/.....	91
2.19.Захиргааны ерөнхий хууль /холбогдох хэсэг/ .....	97
2.20.Хөдөлмөрийн тухай хууль /холбогдох хэсэг/ .....	100
2.21.Төрийн болон албаны нууцын тухай хууль /холбогдох хэсэг/ .....	109
2.22.Шилэн дансны тухай хууль /холбогдох хэсэг/ .....	103
2.23.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /холбогдох хэсэг/.....	107



2.24.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /холбогдох хэсэг/.....	109
2.25.Зар сурталчилгааны тухай хууль /холбогдох хэсэг/ .....	111

### **Гурав. Монгол Улсын олон улсын гэрээ**

3.1. Тээврийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.05/.....	113
3.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай /2015.04.30/.....	114

### **Дөрөв. Улсын дээд шүүхийн тогтоол**

4.1. Автотээврийн тухай хуулийн зарим зүйл , хэсэг , заалтыг тайлбарлах тухай тогтоол /2006.02.20/ .....	115
--	-----

### **Тав. Монгол Улсын Их Хурлын тогтоол**

5.1."Алсын-хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай бодлого /2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоол/ .....	116
--	-----

### **Зургаа. Монгол Улсын Засгийн газрын тогтоол**

6.1.Замын хөдөлгөөний дүрэм батлах тухай /2018.08.08-ны өдрийн 239 дүгээр тогтоол/ .....	125
6.1.1.Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм .....	126
6.1.2.Замын тэмдэг.....	166
6.1.3.Замын тэмдэглэл.....	175
6.1.4.Тээврийн хэрэгслийн таних тэмдэг.....	180
6.2.Тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчлийн жагсаалт .....	182
6.3. Автотээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2009.08.18"ны өдрийн дугаар 251/ .....	185
6.4.Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай /2004.03.03-ны өдрийн дугаар 55/ .....	186
6.5. Автомашин түрээслүүлэх журмыг батлах тухай /1997.06.18-ны өдрийн дугаар 148/ .....	188
6.6. Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн тээврийн үнийг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай /2012.02.15-ны өдрийн дугаар 53/ .....	191
6.7.Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношлогооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай /2016.12.28-ны дугаар 213/ .....	193
6.8. Нийслэлийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2002.01.16-ны өдрийн дугаар 8/ .....	195



6.9.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар , Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны бүтэц , нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай /2020.02.28-ны өдрийн дугаар 81/ .....	197
6.10. Журам батлах тухай /газар чөлөөлөх/, /2024.03.06-ны өдрийн дугаар 91/.....	200
6.11.Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /“Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-ын 3 дугаар хавсралт/, /2017.07.04-ний өдрийн 197 дугаар тогтоол/.....	201
<b>Долоо. Сайдын тушаал</b>	
7.1.Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхний загвар батлах тухай. /Зам , тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, Соёл шинжлэх ухааны сайдын тушаал/ /2010.05.07-ны өдрийн дугаар 161/229/ .....	206
7.2.Тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.12.08-ны өдрийн 317 дугаар тушаал/ .....	226
7.3.Эрх олгох тухай /2016.09.20-ны өдрийн дугаар 31/ .....	231
7.4.Жишиг норм батлах тухай /2019.12.30-ны өдрийн 390 дүгээр тушаал/ .....	232
7.5. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм шинэчлэн батлах тухай /2020.01.30-ны өдрийн А/24 дүгээр тушаал/ .....	242
7.6.Журам шинэчлэн батлах тухай /Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам/, /2020.11.18-ны өдрийн А/222 дугаар тушаал/.....	270
7.7.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилогоо явуулах журам батлах тухай /2021.12.31-ний өдрийн А/199 дүгээр тушаал/ .....	287
7.8. Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам шинэчлэн батлах тухай /2022.04.25-ны өдрийн А/112 дугаар тушаал/ .....	293
7.9.Байгал орчин, аялал жуулчлалын сайд , зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаал /2011 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Дугаар А-63/67/ .....	302
7.10.Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал Журам батлах тухай /Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул , хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам/ /2009 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 188/ .....	306
7.11.Монгол Улсын Зам, тээврийн сайдын тушаал /Авто үйлчилгээний ангилал тогтоох/ /2016.04.12-ны өдрийн дугаар 90/ .....	311



7.12.Журам батлах тухай зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаал /Жишиг норм батлах тухай/ "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм/ /2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 390/ .....328

7.13.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд цагдаагийн ерөнхий газрын даргын дарга нарийн хамтарсан тушаал /2023.07.04-ний өдрийн А 246, А 186 дугаар тушаал/.....329

### **Найм. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн тогтоол**

8.1.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг шинэчлэн батлах тухай /2024.02.08-ны өдрийн дугаар 07/ .....344

8.2.Авто зам ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай /2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр дугаар 02/ .....346

8.3.Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг төлөвлөх , барьж байгуулах журам батлах тухай /2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн дугаар 16/ .....347

8.4.Нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг тогтоох тухай /2024оны 02 дугаар сарын 08-ны өдөр/.....352

8.5.Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай /2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр дугаар 21/ .....353

8.6.Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх захиран зарцуулах, хяналт тавих журам батлах тухай / 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 03/ .....355

8.7.Амьтны хүрээлэн ажлуулах журам батлуулах тухай /2024.02.08-ны өдрийн дугаар 17/ .....359

8.8.Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийг хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай /2024.02.08-ны өдрийн дугаар 09/ .....360

8.9.Оршуултын үйл ажиллагааг эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан, шилжүүлсэн журам батлах /2024.02.08 дугаар 18/ .....361

8.10.Хураамжийн хэмжээ тогтоох тухай /2013.03.28-ны өдрийн 8/34 дүгээр тогтоол/.....362

8.11.“Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам батлах тухай” /2015.10.22-ны өдрийн 6/21 дүгээр тогтоол/ .....363

8.12.Журамд өөрчлөлт оруулах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол /2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 99 дүгээр тушаал/ .....364

8.13.“Хүндэт донор” иргэнийг нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй зорчуулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.06.14-ний өдрийн 95 дугаар тогтоол/ .....365



8.14.Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам /2017 оны 04 дүгээр сарын 27-ны 9/10 дугаар тогтоол/ .....	366
8.15.Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам шинэчлэн батлах тухай /2022.09.07-ны өдрийн 82 дугаар тогтоол/ .....	395
8.16.Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн батлах тухай /2024.02.28-ны 26 дугаар тогтоол/ .....	367
8.17.Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай /2020.12.04-ний 02/09 дүгээр тогтоол/ .....	396

### **Ес. Нийслэлийн Засаг даргын захирамжууд**

9.1.Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Дугаар А/1037/ .....	392
9.2.Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429/ .....	396
9.3.Машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай/2024.03.21-ний өдрийн А 290/ .....	398
9.4.Нийтийн тээврийн бодлогын газрын дүрмийг батлах тухай /2024.05.09-ний А 536/ .....	403



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

**Монголын ард түмэн бид:**

**-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,  
-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг  
эрхэмлэн дээдэлж,**

**-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,**

**-хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,**

**-эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан  
хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн  
хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.**

**Арван гуравдугаар зүйл.**

1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

2.Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ**

**Арван дөрөвдүгээр зүйл.**

1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

**Арван зургадугаар зүйл.**

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;



7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14/Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв



журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

#### **Арван долдугаар зүйл.**

1.Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3/хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

4/эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2.Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

#### **Арван есдүгээр зүйл.**

1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

#### **Далдугаар зүйл.**

1.Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

2.Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

**Мэдэгтүн, сахигтун!**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРАЛ**

**1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдрийн 11 цаг 35 минут Улаанбаатар хот**